



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 601

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 он, 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 161.4 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Ц.Амарсанаад байгууллагын дотоод хяналтыг сайжруулж дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангтан, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

2.2.Барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах, сангийн нягтлан бодох бүртгэл, худалдан авалтын үйл ажиллагааг хууль, журамд нийцуулэх, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллах;

2.3.Барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах болон барилгын салбарын инженер техникийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх, давтан сургах чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлсэн асуудал байгууллагын үйл ажиллагаа, зорилтот түвшинд хэрхэн нөлөөлж буй асуудлаар мэдээлэл бэлтгэж, салбарын яамны удирдлагад танилцуулж чиглэл авч ажиллах;

2.4.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг таслан зогсоох;

2.5.Барилгын аюулгүй байдал, чанар стандартад тавих барилга захиалагчийн хяналтыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлогийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, төрийн өмчийн барилга байгууламжид техникийн аюулгүй байдал, холбогдох бусад асуудлаар дүгнэлт гаргах, барилгын салбарын цахим нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.6.Байгууллагын бүтцэд эдийн засагчийн орон тоо батлуулах арга хэмжээ авах;

2.7. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Тус үйлдвэрийн газрын хэрэгжүүлж буй зарим чиг үүргийг эрх зүйн хувьд зөрчилгүй болгох, өргөжүүлж орлого, үр ашгийг нэмэгдүүлэх, хууль тогтоомж дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллаар Барилга хот байгуулалтын яамтай хамтран ажиллаж, чиг үүргийн өөрчлөлтийг төвийн дүрэмд тусгах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ц.ТҮВШИНЗАЯА


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2020 оны 12 дугаар сарын 08. -ны өдрийн

601 дугаар тогтоолын хавсралт

60981... 1118262...

“Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил, гүйлгээг тайлагнасан	18.6	Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланда тусгахыг хориглоно"	Норм нормативын сангийн зарцуулалтын үйл ажиллагаанд Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт, Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллах.
2	Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчин зохион байгуулсан	142.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 46 дугаар зүйлийн 46.1.4	Худалдан авах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулах.
3	Барилга байгууламжийн норм нормативын сангийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулан бичилт хийж нийт дүнгээр нь тусгаагүй	-	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалтыг зөрчсөн.	Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Барилгын тухай хууль, норм нормативын сангийн журам, холбогдох стандартыг мөрдөж ажиллах.
НИЙТ ДҮН:		161.4		